


# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

## 06.02 - 06.04



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ:** Эдийн засаг сэргэж байгаатай холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээл сүүлийн 2 сарын хугацааны хамгийн өндөр өсөлтийг үзүүлээ. Технологийн салбарын компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq Composite индекс бүх цаг үеийн хамгийн өндөр түвшинд хүрсэн ба S&P500 индекс 2-р сарын 19-ний буюу бүх цаг үеийн хамгийн дээд түвшнээс 6%-аар бага байна.

ОРЕС болон томоохон газрын тосны үйлдвэрлэгчид орнууд үйлдвэрлэлээ танах магадлалтай байгаагаас газрын тосны үнэ өсөж, S&P500 индексийн сагсанд багтах эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байлаа. Урт хугацаат хүүгийн түвшин өссөнөөр банкны зээлийн маржинд эергээр нөлөөлж, санхүүгийн салбарын компаниудын хувьцаа мөн өсөлттэй байсан ба Boeing компанийн хувьцааны ханш өссөн нь аж үйлдвэрийн салбарын өсөлттэй байхад нөлөөлжээ. Харин өргөн хэрэглээний бараа үйлчилгээний болон эрүүл мэндийн салбарын хувьцаа энэ долоо хоногт харьцангуй өсөлт багатай байсан байна.

Энэ 7 хоногт хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд хүлээлтээс сайн гарсан нь хөрөнгийн зах зээлийн индексүүдэд ихээр нөлөөллөө. ADP агентлагийн ажил эрхлэлтийн тайланд тусгагддаг сар тутмын цалингийн өөрчлөлт өнгөрсөн сард таамаглалаас харьцангуй бага бууралттай гарсан нь Лхагва гарагт компаниудын хувьцааны ханш огцом өсөхөд нөлөөлжээ.

**Европ:** Европын улс орнууд хөл хоригоо цуцалж байгаагаас гадна Европын Төв Банкнаас евро бүсийн эдийн засгийг дэмжих шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь хувьцааны ханш өндөр өсөхөд нөлөөлжээ. STOXX Europe 600 индекс 6.91%, Xetra DAX индекс 10.60%, CAC 40 индекс 10.47%, FTSE MIB индекс 10.71%, FTSE 100 индекс 6.45% тус тус өссөн байна.

ЕТБ-ны зүгээс евро бүсийн эдийн засгаа эрчимтэй дэмжиж байгаа нь гол бондуудын өгөөж өсөхөд нөлөөлжээ. Герман улсын засгийн газрын 10 жилийн хугацаатай bund-ийн өгөөж долоо хоногийн эхэнд байснаасаа 0.11% буюу 11 суурь пунктээр өсөж Баасан гарагт -0.3% болсон байна.

**Япон:** Энэ долоо хоногт Япон улсын томоохон хувьцааны ханш урт хугацааны өсөлтийн чиглэлээ хадгалсан байна. Nikkei 225 Stock Average индекс 986 пункт буюу 4.5% өсөлт үзүүлж 22,863.73 болсон боловч өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 3.4% бага байгаа юм. Гэхдээ тус индекс нь 3 дахь 7 хоногтоо дараалан өссөөр байгаа ба 3-р сарын уналтын ихэнх хэсгээ нөхөөд байна. Баасан гаргийн байдлаар 1 ам.доллар 109.17 иентэй тэнцүү байна.

**БНХАУ:** АНУ болон БНХАУ-ын харилцаа сайжирч байгаа нь энэ 7 хоногт БНХАУ-ын хөрөнгийн зах зээл өсөлттэй байхад нөлөөлжээ. Дотоодын CSI 300 индекс 3.4% өссөн бол Shanghai Composite индекс 2.8% өссөн байна.

АНУ-ын Худалдааны Төлөөлөгч Роберт Лайтхайзер Пүрэв гарагт БНХАУ-тай байгуулсан 1-р шатны худалдааны хэлэлцээрийн гүйцэтгэлийн талаар үнэхээр сэтгэл хангалуун байгаагаас мэдэгдсэн ба гэрээний заалтуудыг бүтцийн түвшинд өөрчлөлт гарган хэрэгжүүлж байгаа нь "маш сайн" хэмээн магтжээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,213.52	1.45% ▲
Dow Jones	АНУ	27,110.98	6.81% ▲
S&P 500	АНУ	3,193.93	4.91% ▲
Nasdaq	АНУ	9,814.08	3.42% ▲
S&P/TSX	Канад	15,854.07	4.35% ▲
FTSE 100	Их Британи	6,484.30	6.71% ▲
S&P/ASX 200	Австрали	5,998.70	4.22% ▲
Nikkei 225	Япон	22,863.73	4.51% ▲
Hang Seng	Хонг Конг	24,770.41	7.88% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	106.00
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	98.81
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	98.71
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.20
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.09
DBM' 2023	USD	7.250%	87.44
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	83.95

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.180	0.00 ▼
Libor 3M	0.313	-0.03 ▼
Libor 6M	0.481	-0.03 ▼
Libor 1YR	0.634	-0.04 ▼
US 2YR Bond	0.204	0.05 ▲
US 3YR Bond	0.278	0.09 ▲
US 5YR Bond	0.460	0.16 ▲
US 10YR Bond	0.892	0.24 ▲

Валютын ханш	2020.06.05	Өөрчлөлт
USD	2,809.64	0.13% ▲
CNY	394.61	0.51% ▲
EUR	3,147.36	1.01% ▲
RUB	40.72	2.72% ▲
KRW	2.31	1.76% ▲
JPY	25.76	-1.60% ▼
CAD	2,078.67	2.06% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,685.06	-2.61% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	17.42	-2.52% ▼
Зэс	USD/lb.	255.55	5.36% ▲
Нүүрс	USD/MT	56.70	2.49% ▲
WTI газрын тос	USD/bbl.	39.55	11.44% ▲
Brent газрын тос	USD/bbl.	42.30	19.73% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	1.78	-3.78% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. IV	4.7%
Бодлогын хүү	2020. IV	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. IV	9.87%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. IV	11.32%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. IV	4.57%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. IV	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. IV	10.36%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 45 компанийн 281.0 сая төгрөгийн 2,557,249 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“МИК холдинг” /MIK/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 2,578.00 төгрөг хүрч хаагдсан бол “Авто импекс” /AOI/ компанийн хувьцаа 14.71%-аар буурч 1,450.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


06-р сарын 04-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,461.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,213.52 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.45%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоног, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Зах зээлийн тойм

Арилжигдсан үнийн дүн	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	281.0
Зах зээлийн үнэлгээ	2,461,280.4

### Зах зээлийн индексүүд

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,213.52	1.45% ▲
MSE I индекс	8,020.41	3.87% ▲
MSE II индекс	7,399.45	1.09% ▲

### Идэвхтэй арилжагдсан хувьцаа

Хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Лэндмн ББСБ	1,945,762	61,152,341
Монгол шуудан	93,285	56,004,414
АПУ	53,893	29,164,561
Ариг гал	9,830	26,145,940
Адуун чулуун	21,921	22,359,420

### Өсөлттэй хувьцаа

Хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
МИК холдинг	12,650.00	15.00% ▲
Атар-Өргөө	74,500.00	14.79% ▲
Хар хорум пропертийс	330.00	13.79% ▲
Эрдэнэт хүнс	3,400.00	13.33% ▲
Хөвсгөл алтан дуулга	690.00	7.81% ▲

### Бууралттай хувьцаа

Хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Авто импекс	1,450.00	-14.71% ▼
Их барилга	2,000.00	-12.66% ▼
Дөрвөн-Уул	580.00	-10.77% ▼
Махимпекс	2,405.00	-9.25% ▼
Лэндмн ББСБ	30.17	-3.98% ▼

### Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК

ҮЦК	Дүн (төг)
Би Ди Сек	219,100,778
Мирэ Эссет Секьюритис Монгол	75,648,644
Гаули	61,110,205
Бумбат-Алтай	47,944,166
Ард секьюритиз	47,604,631

### Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	541.77	576,542
Таван толгой	5,700.00	300,192
МИК холдинг	12,650.00	261,973
Инвекор ББСБ	2,500.00	179,320
Говь	192.81	150,413

### Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХУНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-НИЙ ДОТОР
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



### ОНЦЛОХ МЭДЭЭ

“Бодь даатгал” ХК-ийн үнэт цаасны андеррайтер “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн хүсэлтийн дагуу тус компанийн үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалгыг 2020 оны 06-р сарын 02-ээс 2020 оны 06-р сарын 04-ний өдрүүдэд 08:30-18:00 цагийн хооронд, 06-р сарын 08-ны өдөр 08:30-17:00 цаг хүртэл хүлээн авахаар хуваарьт өөрчлөлт орууллаа.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

### ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

**“Хорин хоёрдугаар бааз” /MSE: АНН/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр.**

“Хорин хоёрдугаар бааз” /MSE: АНН/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит бус хурал 2020 оны 05-р сарын 28-ны 13:00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Энх тайвны өргөн чөлөө өөрийн байранд болов.

Хуралд:

- “Монгол секюритиес ҮЦК” /MSE: MSC/ ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
- Т. Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Л. Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- З. Номундарь 1,399,412 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- “Чингис Хаан секюритиес” ХХК 56,870 ширхэг хувьцааны саналаар /захирал/

1,945,050 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 73.3%-ийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Хурлыг Т. Зоригтбаатар удирдав.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн байна:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт
3. Санхүүгийн тайланд хийсэн Аудитийн дүгнэлт.
4. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
5. Төслийн санхүүжилтийн тухай
6. ТУЗ-ийн Гишүүдийг томилох
7. Бусад

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

**“Могойн гол” /MSE: BDL/ ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэр.**

“Могойн гол” /MSE: BDL/ ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 02-р сарын 18-ны өдрийн № 1-р тогтоолоор “Могойн гол” /MSE: BDL/ ХК 2019 онд 1,200.00 сая төгрөгийн өртэй байгаа тул 2019 оны ногдол ашгийг хуваарилахгүй байх шийдвэр гаргасан тухайгаа 2020 оны 06-р сарын 02-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан мэдээлсэн байна.

Тус компани нь 2019 онд 3,173.4 сая төгрөгийн нийт борлуулалтын орлого, 673.2 сая төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд 2019 оны эцсийн байдлаар нийт 5,250.0 сая төгрөгийн нийт хөрөнгө, 3,131.8 сая төгрөгийн эзний өмчтэй байгаа юм.

Компанийн хувьцаа нь Монголын Хөрөнгийн Биржийн 2-р ангилалт бүртгэлтэй ба хамгийн сүүлд 2020 оны 05-р сарын 25-ны өдөр тус компанийн 3 ширхэг хувьцаа 7,000 төгрөгийн ханштай арилжаалагдсан байна.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

**“Атар-Өргөө” /MSE: ATR/ ХК-ийн хувьцааны ханш 2018 оны 10 сараас хойшхи дээд түвшинд хаагдав**

2020 оны 06-р сарын 04-ны арилжаагаар МХБ-ийн үнэт цаасны II ангилалд бүртгэлтэй “Атар-Өргөө” /MSE: ATR/ ХК-ийн хувьцааны ханш 14.79%-аар өсч 74,500 төгрөгт хүрлээ.

Энэ нь тус компанийн ханшийн тухайд 2018 оны 10 сараас хойших хамгийн дээд үзүүлэлт болж байгаа бөгөөд 2019 оны жилийн эцсээс 23.6%-аар өсөөд байна.

Хэдийгээр ханш өсөлттэй байгаа ч зах зээл дээр хувьцааны арилжаа нь идэвх сул байсаар байгаа ба 2 жилийн хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж дээр 36 өдөр арилжигджээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

COVID-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, Пандемик (цар тахал)-ын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулах зорилгоор улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх долоо хоног тутмын гадаад орчны тойм мэдээллийн арван нэг дэх дугаарыг хүргэж байна.

Глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд 5-р сарын 22-оос 5-р сарын 29-ний байдлаар гарсан өөрчлөлтийн тоймыг [эндээс](#) татаж авна уу.

Эх сурвалж: Монголбанк



### МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк 2020 оны 05-р сард 1.7 тонн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 8.5 тонн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4.3 тонноор өссөн үзүүлэлт юм. Монголбанкны нийт худалдан авсан 8.5 тонн үнэт металлын 6.8 тонн нь алт, 1.7 тонн нь цагаан мөнгө байна.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 05-р сард 154,048.51 төгрөг байлаа

Эх сурвалж: Монголбанк

### ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Оны эхний 5 сард Монгол Улс 60.5 сая ам.долларын жонш экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 20%-аар бага байна. Харин биет хэмжээгээр жилийн өмнөхөөс 6.4%-аар өсөж, 237 мянган тонн болсон талаар Гаалийн ерөнхий газрын урьдчилсан гүйцэтгэлд дурдлаа.

Одоогоор жоншийг Замын-Үүд, Хавирга, Бичигт, Сэлэнгийн боомтоор БНХАУ, ОХУ-ын зах зээлд экспортолж байна. ОХУ-д цар тахал эрчимжсэнээр худалдаанд бэрхшээл учирч магадгүй гэж болгоомжилж байгаа талаар “Баялаг жонш” компанийн Ерөнхий захирал онцолж байв.

Эх сурвалж: BloombergTV.mn



### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.